

Хяналт шалгалт хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Булган аймгийн засаг даргын баталсан 2017 оны 05 сарын 22-ны өдрийн 01/14 тоот удирдамж, Булган аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтыг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Алтанхуяг
2017 оны 05 дугаар сарын 23-аас ажлын 7 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Хутаг-Өндөр сумын Бүрэн дунд сургууль, Хантай, Уньт багийн бага сургуулийн 2015, 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. 2015 онд Бүрэн дунд сургууль нь 90 жилийн ойн хандивт “Хутаг-өндөр төгсөгчдийн холбоо” ТББ-ын ХААН банкн дахь 52841732905 тоот дансаар 49,567,700 төгрөг цуглаж зарцуулагдсан байна. Харин бэлнээр 44,726,000 төгрөг цуглаж зарцуулагдсан гэх боловч тодорхой бус байна. Эдгээр хандивийн орлого зарлагын баримтын бүрдэл дутуу, тухайн байгууллагын тайлан балансад тусгаагүй байгаа нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 6.3.4-д /Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх/ заасан заалтыг зөрчсөн байна.

2. Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа микро автобусыг 2013 оны 07 сарын 31 ны өдөр Иргэн Батнасан овогтой Одгаригд аймгийн Орон нутгийн өмчийн газарт мэдэгдэлгүй, ямар нэгэн шийдвэр гараагүй байхад 1,000,000 төгрөгөөр үнэлэн зарсан байгаа нь Булган аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2014 оны 01 сарын 23 ны өдрийн 17 тоот тогтоолоор баталсан Орон нутгийн өмчит хуулийн

этгээд үндсэн хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журмын 4 болон 7-р зүйлийг зөрчсөн байна.

3. Сахиул ажилтай Ч.Батбилэгт 2016 оны 6,7 сард амралт давхардуулан бодож олгосон бөгөөд илүү олгосон 984,899 төгрөгийг буцааж суутгасан боловч 187130 төгрөгийг дутуу суутгаж данс бүртгэлд тусгаагүй нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4.2-д /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ заасан заалтыг зөрчсөн байна.

4. Захирал Д.Ган-Эрдэнэд 2016 оны 09 сарын 09-ны өдөр Төрийн банкны 121600029551 тоот дансанд томилолтын зардалд 80,000 төгрөг шилжүүлсэн боловч томилолтын үнэмлэх болон ажлын удирдамжгүй, нягтлан бодогч асан Л.Буяннэмэхэд 2016 оны 08 сарын 08 ны өдөр Хаан банкны 5284088860 тоот дансанд томилолтын зардал олгохдоо замын зардал төлсөн баримтгүйгээр 24,000 олгосон байгаа зэрэг нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтыг зөрчсөн байна.

5. Цалингийн тооцооны хүснэгт болон гарт олгох хүснэгтэд ажиллагсдын гарын үсгийн бүрдэл дутуу.

6. Шилэн дансны нэгдсэн сайтад Бүрэн дунд сургууль нь 2016 онд 149 мэдээлэл байршуулахаас 141 мэдээлэл байршуулж 8 мэдээлэл огт мэдээлээгүй, Хантай бага сургууль нь 144 мэдээлэл байршуулж 5 мэдээлэл огт мэдээлээгүй, Уньт бага сургууль 140 мэдээлэл байршуулж 9 мэдээлэл огт мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д /Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 сарын 25-ны өдрийн дотор, сар, улиралын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор/, мөн хуулийн 8.2-д /Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ/ заасан заалтуудыг зөрчсөн байна.

. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 3 актаар 1,291,130 төгрөгний төлбөр тогтоов.

Зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 5 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус байгууллагад Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7 дахь заалтууд, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэл дутуу, шатахууны тайланг нягтлан бодогч шалгаж хүлээн аваагүй, тооцоо бодолт хийдэггүй, гарын үсэг

зураагүй, жолоочийн тооцооны хуудасыг авсан шатахуундаа тааруулан бичдэг байгаа нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй, захирал нягтлан бодогчийн ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

Цаашид авах арга хэмжээний санал

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг биелүүлж ажиллах.

2. Хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журмын үйл ажиллагаандаа баримталж ажиллах.

3. Байгууллагын дотоод журмыг хуульд нийцүүлэн шинэчилж өөрчлөх

4. Дотоодын хяналт шалгалтыг сайжруулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ